



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/26


Бат-Өлзий сум

Сар шинийн баярын үеэр авах арга
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.8 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сар шинийн баярыг тохиолдуулан нийгмийн хэв журам сахиулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын хэвийн ажиллагааг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амгалан тайван, аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалахад хяналт тавьж, зохицуулах цагдаа, албан хаагчдын эргүүлийн хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Сар шинийн баярын өдрүүдэд аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгийг хамгаалах, халаалтын хэвийн ажиллагаанд хяналт тавин, эргүүл томилон ажиллуулахыг төрийн байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.
3. Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ), Цагдаагийн тасгийн дарга, (Цагдаагийн хошууч Энх-Амгалан) нарт ДААЛГАХ нь:
 - а. Эргүүлээр ажиллах албан хаагч, жолооч нарт үүрэг даалгавар өгч батлагдсан хуваарийн дагуу ажиллуулж, автомашиныг зөвшөөрлийн дагуу шатахуунаар хангах.
 - б. Баярын үеэр гарч болзошгүй гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулах.
 - в. Гарсан гэмт хэрэг зөрчлийн талаар сумын удирдлага, холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэж унаа, хүн хүчний туслалцаа авч ажиллах.
 - г. Эргүүлээр ажилласан ажлын дүнг нэгтгэн 2022 оны 02 дугаар сарын 28-нд танилцуулах.
4. Төсөвт байгууллагуудын уурын зуухны халаалтын хэвийн ажиллагааг хангаж ажиллахыг “Арвин бумба-Очир” Хязгаарлагдмал хариуцлагатай компани (Х.Нямлхагва), (А.Гантулга) нарт үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН



C:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

622301050

Сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар
сарын 17-ны өдрийн А/26 дугаар
захирамжийн хавсралт



ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛИЙН ХУВААРЬ

Д/д	Төрийн байгууллагын нэр	Эргүүлээр ажиллах хугацаа (өдөр бүр 18:00 цагаас 24:00 цаг)	Хөдөлгөөн эргүүлийн авто машин
1	ЭМТөв	2023 оны 02 дугаар сарын 20 буюу битүүн	Цагдаагийн тасгийн 56-66 ӨВЕ дугаартай фургон маркийн авто машин
2	ЗДТГазар	2023 оны 02 дугаар сарын 21 буюу шинийн 1	Цагдаагийн тасгийн 56-66ӨВЕ дугаартай фургон маркийн авто машин
3	Ерөнхий боловсролын сургууль	2023 оны 02 дугаар сарын 22 буюу шинийн 2	Цагдаагийн тасгийн 56-66 ӨВЕ дугаартай фургон маркийн авто машин
4	1 дүгээр Цэцэрлэг	2023 оны 02 дугаар сарын 22 буюу шинийн 3	Цагдаагийн тасгийн 56-66 ӨВЕ дугаартай фургон маркийн авто машин
5	2 дугаар Цэцэрлэг	2023 оны 02 дугаар сарын 23 буюу шинийн 4	Цагдаагийн тасгийн 56-66 ӨВЕ дугаартай фургон маркийн авто машин

Жич: Албан байгууллага бүрээс 2 албан хаагч, Цагдаагийн тасгийнхантай хамтран ажиллана.

-оОо-